**ЭРЧИМ ХҮЧНИЙ**
**ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 09 сарын 30 өдөр | Дугаар А/137 | Улаанбаатар хот

Маягт батлах тухай

Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.7, "Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрчим хүчний аудитын тайлан үнэлэх маягтыг нэгдүгээр, аудитын мэдээний маягтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Батлагдсан маягтуудын дагуу тайлан, мэдээг хүлээн авч, эрчим хүчний аудитор, эрчим хүчний аудитын магадлан итгэмжлэл эзэмшигчийн тухайн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нь үнэлэн, тайлагнаж ажиллахыг Эрчим хүч хэмнэлтийн газар /Ц.Атаржаргал/-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /М.Мөнхтулга/-т даалгасугай.

ДАРГА А.ТЛЕЙХАН

Эрчим хүчний зохицуулах хорооны даргын
2019 оны А/137 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# Эрчим хүчний аудитын тайлан үнэлэх маягт

Үйлчлүүлэгчийн мэдээлэл: Хуулийн этгээдийн нэр: ..............................
Аудит хийлгэсэн объектын хаяг, байршил: ..............................
Хуулиар үүрэг хүлээсэн хэрэглэгч мөн эсэх: ..............................

Гүйцэтгэсэн
Аудитын байгууллага: ..............................
Аудитор/-ууд: 1. ..............................
2. ..............................
3. ..............................
4. ..............................

Гүйцэтгэсэн аудитын үйл ажиллагааны чиглэл ..............................
*/үйлдвэрлэлийн эрчим хүчний аудит: цахилгаан эсхүл дулаан, барилгын эрчим хүчний аудит/*

Үнэлсэн ЭХХГ-ын мэргэжилтэн: .............................. /....................................../ Огноо ........................................
гарын үсэг нэр

*Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 1-ний 181 дүгээр тогтоолоор баталсан "Эрчим хүчний аудит хийх журам"-ын 2, 3, 4, 5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн эрчим хүчний аудитын тайланг дараах байдлаар үнэлнэ.*

| Аудитын үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд | Д/д | Шалгуур үзүүлэлтүүд | Авбал зохих оноо | | | Өгсөн оноо | Санал, дүгнэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Анхан шатны аудит | Хэсэг-чилсэн аудит | Дэлгэ-рэнгүй аудит | | |
| 1. Аудитын гэрээ, түүний хэрэгжилт | 1.1 | ЭХЗХ-оос баталсан аудитын гэрээний загварын хүрээнд аудит хийх гэрээ байгуулсан эсэх; | 5 | 5 | 5 | | |
| | 1.2 | Аудитын байгууллага, аудитор тухайн үйлчлүүлэгчтэй хамтран аудит хийх төлөвлөгөө гаргасан эсэх; | 3 | 3 | 3 | | |
| | 1.3 | Аудитын гэрээний хэрэгжилтийг талууд хамтран дүгнэсэн эсэх; | 2 | 2 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.1 | Ажлын байранд үзлэг хийх, үйлчлүүлэгчээс тайлбар, тодруулга авах, ярилцах, ажлын зохион байгуулалтыг төлөвлөх, танилцуулах, үйл ажиллагааг ажиглах, өгөгдөл мэдээлэл цуглуулах, хэмжилт, туршилт, судалгаа, дүн шинжилгээ хийсэн эсэх; | 20 | 10 | 10 | | |
| 2. Аудитын үйл ажиллагаа холбогдох журам, стандартад нийцсэн байдал | 2.2 | Өгөгдөл, мэдээллийг боловсруулж, эрчим хүчний хэрэгцээ болон бодит хэрэглээний тэнцэлд шинжилгээ хийсэн эсэх; | 15 | 10 | 10 | | |
| | 2.3 | Үйлчлүүлэгчийн эрчим хүчний хэрэглээ нь холбогдох норм, стандарт, харьцуулалтад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон эсэх; | 0 | 5 | 5 | | |
| | 2.4 | Эрчим хүч хэмнэх нөөц боломж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон эсэх; | 15 | 10 | 10 | | |
| | 2.5 | Аудитын дүгнэлт гаргаж, аудитын үйл ажиллагааны тайлан боловсруулсан байдал; | 15 | 10 | 10 | | |
| | 2.6 | Эрчим хүч хэмнэх талаар зөвлөмж гаргаж, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байдал; | 0 | 5 | 5 | | |
| | 2.7 | Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төлөвлөгөөг боловсруулж, үйлчлүүлэгчтэй хамтран баталгаажуулсан эсэх; | 0 | 10 | 10 | | |
| | 2.8 | Үйлчлүүлэгчид аудитын үйл ажиллагааны үр дүн, зөвлөмжийг танилцуулсан эсэх; | 15 | 10 | 10 | | |
| 3. Аудитын дүгнэлт, зөвлөмж | 3.1 | Тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжүүд нь тооцоо судалгаа, нотолгоонд тулгуурласан эсэх; | 10 | 10 | 10 | | |
| | 3.2 | Тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжүүд нь хөрөнгө оруулалт, түүний үр өгөөжийг тооцсон эсэх; | 0 | 10 | 10 | | |
| 4. Оноо хасах нөхцөлүүд | 4.1 | Гүйцэтгэсэн аудитын мэдээг тухай бүр буюу аудитын тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгснөөс хойш 14 хоногт багтаан ирүүлсэн эсэх; | 10 | 10 | 10 | | |
| | 4.2 | Зөвлөмжид тусгаж болохуйц арга хэмжээнүүдийг орхигдуулсан эсэх | 5 | 5 | 5 | | |
| | 4.3 | Үйлчлүүлэгчээс тухайн аудитын үйл ажиллагаатай холбоотой санал, шүүмж ирүүлсэн эсэх | 5 | 5 | 5 | | |

Тайлбар: Тайлант жилд гүйцэтгэсэн эрчим хүчний аудитын тайлан тус бүрт өгсөн онооны дундажтай уялдуулан аудитор, магадлан итгэмжлэл эзэмшигчийн үйл ажиллагааг дараах байдлаар үнэлнэ. Үүнд: онооны дундаж 90-ээс 100 хүртэл бол "хангалттай сайн", онооны дундаж 75-аас 90 хүртэл бол "сайн", онооны дундаж 60-аас 75 хүртэл бол "дунд", онооны дундаж 60 хүртэл бол "хангалтгүй". Аудитор, магадлан итгэмжлэл эзэмшигч нь тайлант жилд эрчим хүчний аудит гүйцэтгээгүй бол үйл ажиллагааг нь үнэлэхгүй.

*Эрчим хүчний зохицуулах хорооны даргын*
*2019 оны А/137 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

**Эрчим хүчний аудитор, магадлан итгэмжлэл эзэмшигчийн гүйцэтгэсэн аудитын мэдээний маягт**

*/аудитор, магадлан итгэмжлэл эзэмшигчээс тухай бүр ирүүлэх/*

| Мэдээллийн бүрдэл | | Мэдээлэл | | |
|---|---|---|---|---|
| **1. Үйлчлүүлэгчийн мэдээлэл** | Хуулийн этгээдийн нэр | | | |
| | Аудит хийлгэсэн объектын хаяг, байршил | | | |
| | Хуулиар үүрэг хүлээсэн хэрэглэгч мөн эсэх | Хариултаас сонгох: Тийм / Үгүй | | |
| | Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл эрчим хүчний хэмнэлт, үр ашиг хариуцсан холбогдох ажилтны мэдээлэл | Нэр<br>Албан тушаал<br>Утас<br>Имэйл | | |
| **2. Аудиторын/ аудитын байгууллагын мэдээлэл** | Нэр | | | |
| | Холбоо барих хаяг, утас | | | |
| **3. Эрчим хүчний аудитын тайлан** | Гэрээний хугацаа | | | |
| | Гүйцэтгэсэн аудиторууд | *анхан шатны* | *хэсэгчилсэн* | *дэлгэрэнгүй* |
| | *цахилгаан* | | | |
| | *дулаан/ уур* | | | |
| | *барилга* | | | |
| | Аудитын хамрах цар хүрээ *\/алба, хэлтэс, нэгж, цех, технологийн процесс/* | | | |
| | Аудитын тайлан, зөвлөмжийг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгч, тайлагнасан огноо | | | |
| **4. Аудитын мэдээг баталгаажуулсан** | Эрчим хүчний аудитор/ Аудитын байгууллагын төлөөлөл<br>.............................. /....................................../<br><br>Үйлчлүүлэгч байгууллагын Эрчим хүчний хэмнэлтийн менежер / эрчим хүчний хэмнэлт, үр ашиг хариуцсан ажилтан<br>........................................./........................................./ | Огноо 20... оны ... сарын ... өдөр | | |